



## Шинжээчийн тайлан

**Байгууллагын нэр:** Санхүү Эдийн Засгийн Их Сургууль

**Хөтөлбөрийн нэр:** Маркетинг

**Индекс:** D041401

**Шинжээчийн баг:**

**Ахлагч:** О.Бурмаа /ОУУБИС-ийн Бизнес удирдлагын тэнхимийн дэд профессор, доктор/

**Гишүүд:** Л.Отгонцэцэг / ШУТИС-Бизнесийн удирдлага, Хүмүүнлэгийн сургуулийн зөвлөх профессор, доктор/

С.Бурмаа / МУИС-Бизнесийн сургуулийн дэд профессор, доктор/

## **АГУУЛГА**

### **Товчилсон үгийн тайлбар**

#### **I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт**

#### **II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга**

#### **III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт**

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

#### **IV. Уулзалтад оролцогчдын нэрс**

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

#### **V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**

#### **VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр**

#### **VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр**

## Товчилсон үгийн тайлбар

1. АНУ – Америкийн Нэгдсэн Улс
2. БМИҮЗ – Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл
3. БУТ – Бизнес Удирдлагын Тэнхим
4. БСА – Бакалаврын Сургалтын Алба
5. БСШУЯ – Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам
6. ОХУ – Оросын Холбооны Улс
7. НЗДТГ – Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар
8. СЭЗИС – Санхүү Эдийн Засгийн Их Сургууль
9. ТУЗ – Төлөөлөн Удирдах Зөвлөл
10. ЭШ – Эрдэм шинжилгээ
11. ACBSP – Accreditation Council for Business Schools and Programs

## I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

<b>Сургуулийн нэр /Монгол, Англи/</b>	Санхүү Эдийн Засгийн Их Сургууль University of Finance and Economics	
<b>Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/</b>	Маркетинг Marketing	
<b>Индекс</b>	D041401	
<b>Шинжээчид</b>	<ol style="list-style-type: none"> <li>Овог нэр: Отгонбаяр Бурмаа Ажил албан тушаал: Ахлагч Ажлын газар: ОУУБИС-ийн Бизнес удирдлагын тэнхимийн дэд профессор, доктор</li> <li>Овог нэр: Лхамсүрэн Отгонцэцэг Ажил албан тушаал: гишүүн Ажлын газар: Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн Бизнесийн удирдлага, Хүмүүнлэгийн сургуулийн зөвлөх профессор, доктор, профессор</li> <li>Овог нэр: Сампил Бурмаа Ажил албан тушаал: гишүүн Ажлын газар: Монгол Улсын Их Сургуулийн Бизнесийн сургуулийн дэд профессор, доктор</li> </ol>	
<b>БМИҮЗ-ийн Мэргэжилтэн</b>	Н.Түмэнжаргал. БМИҮЗ-ийн Ажлын албаны магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн	
<b>Төлөвлөгөө</b>	<b>Он сар өдөр</b>	<b>Хийгдсэн байх ажлууд</b>
	I/27	Шинжээчийн багийг томилсон тушаалтай танилцах
	I/27	Мэргэжилтэнд шинжээчдийн багаас ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаар санал өгөх
	I/27	Шинжээчид гэрээ байгуулах
	I/27	Шинжээчид өөрийн үнэлгээний тайланг хүлээн авах.
	I/03	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	I/05-06	Сургууль дээр очиж шинжээчид ажиллана.
	I/18	Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	I/19	Шинжээчдийн үнэлгээний тайланг сургуульд илгээж санал авна.
	I/24	Сургууль үнэлгээний тайлантай танилцаж, тайлбар, нотлох баримтыг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	I/26	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ.
	Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар шинжээчийн үнэлгээний тайланг танилцуулж шийдвэрлүүлнэ.	
<b>Шалгуур шаардлага /журам/</b>	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Хөтөлбөрийн урьдчилсан магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага”	

## II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Хөтөлбөрийн нэр, индекс	Хөтөлбөрийн багийн ахлагч	Сургалтын хэлбэр	Хугацаа	Кредит
Маркетинг D041401	Т.Алтангэрэл	өдөр	4 жил	130

СЭЗИС нь 2009 оноос эхлэн “Маркетинг менежмент” (одоогийн “Маркетинг” хөтөлбөр) хөтөлбөрөөр элсэлт авч, анхны төгсөлтөө 2013 онд хийсэн байна.

2014 оноос БШУ-ны сайдын А/78 тоот тушаалаар шинэчлэн баталсан мэргэжлийн чиглэл, индексийн дагуу “Маркетинг” мэргэжил 041401 индекстэй болон өөрчлөгдсөн.

“Маркетинг” хөтөлбөр нь 2012 онд олон улсын бизнесийн сургуулиудын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг ACBSP байгууллагаас итгэмжлэн баталгаажуулж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөр юм.

#### **Мэргэжлийн тодорхойлолт:**

Маркетингийн мэргэжил нь байгууллага, хэрэглэгчид, хамтрагчид болон нийгэмд үнэ цэнийг бүтээх, хүргэх, хөгжүүлэх зорилго бүхий маркетингийн төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үр дүнг хэмжих, хянах мэдлэг болон чадваруудын цогц юм.

#### **Хөтөлбөрийн зорилго:**

Байгууллагын орчинд маркетингийн асуудлуудыг шинжлэх, төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, үйл ажиллагааг гардан зохион байгуулах, багаар ажиллах болон бизнесийн харилцааны өндөр мэдлэг, чадварыг олгоход чиглэнэ.

### **III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт**

#### **Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт**

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

##### **1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага**

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Маркетинг мэргэжлийн хөтөлбөрийг СЭЗИС болон БУТ-ийн сургалтын туршлага, Монгол улсын хууль тогтоомж, СЭЗИС-ийн эрхэм зорилго, дүрэм, журмын хүрээнд үндэслэн боловсруулсан.
- Маркетинг мэргэжлийн эрэлт, хэрэгцээг дэлхийн эдийн засгийн форумын судалгаа, НЗДТГ-ын дэргэдэх Хүүхэд залуучуудын хөгжлийн газрын хийсэн ирээдүйд Монгол улсад эрэлттэй байх мэргэжлийн судалгаа, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Судалгааны Институтын хийсэн эрэлттэй байгаа 250 мэргэжлийн судалгаа, ажил олгогч болон төгсөгчийн судалгааны үр дүн, ижил төстэй мэргэжлийн хөтөлбөрийн агуулга, арга зүйгээс бенчмаркинг хийж тодорхойлдог байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Нийгэм, эдийн засаг, салбарын тэргүүлэх чиглэл, сонирхогч талуудын судалгаа, түүний үр дүнд тулгуурлан хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон.
- Маркетингийн шинжлэх ухааны орчин үеийн чиг хандлагад нийцүүлэн олон улсад туршлага болж буй шинэ хичээлүүдийг нэмж оруулсан.

### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлоход оролцогч болон сонирхогч талуудын оролцоог нэмэгдүүлэх олон ажлууд өрнүүлж байгаа ч санал, зөвлөмжүүдийг баталгаажуулах

### **Зөвлөмж:**

- Мэргэжлийн хөтөлбөрийн харьцуулалтыг хийхдээ дотоодын төрийн болон хувийн өмчийн их, дээд сургуулийн илүү олон маркетингийн хөтөлбөртэй харьцуулан, онцлог талуудыг тодорхойлох

### **1.2 Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

### **Илрэл нотолгоо:**

- Сургуулийн эрхэм зорилго нь олон улсын жишигт хүрэхүйц мэргэжилтэн бэлтгэхэд чиглэгдсэнтэй уялдуулан маркетингийн мэргэжлийн тодорхойлолт, төгсөгчдийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагуудыг мэргэжлийн хөтөлбөрт шинэчлэн тодорхойлсон.
- Мэргэжлийн хөтөлбөрийн зорилго, агуулгад оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн сайжруулах зорилгоор ажил олгогч болон төгсөгчийн төлөөлөлтэй, СЭЗИС болон тэнхимийн багш нар хамтарсан хэлэлцүүлгийг зохион байгуулдаг.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Маркетинг хөтөлбөр нь сургуулийн эрхэм зорилго, алсын хараа, стратеги төлөвлөгөөтэй нягт уялдаа холбоотой боловсруулан хэрэгжүүлж, үр дүнг тогтмол үнэлж, сайжруулалтыг тасралтгүй хийсээр байна.

### **Анхаарах асуудал:**

- СЭЗИС-ийн “Маркетинг” хөтөлбөрийн бусад ижил төрлийн хөтөлбөрөөс ялгагдах онцлогийг хөтөлбөрийн зорилго дээр илүү тодорхой харьцуулж харуулах
- Хөтөлбөрийн зорилго, агуулгыг шинэчлэхэд оролцогч талуудаас авч буй олон төрлийн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байгааг баталгаажуулах

### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн зорилтыг зөвхөн мэдлэг, ур чадвараар тодорхойлж, хандлага төлөвшил эзэмшүүлэх чиглэлийг орхигдуулсаныг засварлах

### **1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Бизнесийн орчин, ажил олгогч талуудын хэрэгцээ шаардлага, СЭЗИС-ийн стратеги төлөвлөгөөний өөрчлөлтөд нийцүүлэн 2009 оноос тухайн хөтөлбөрийг 5 удаа шинэчлэн өөрчилсөн.
- “Бакалаврын сургалт зохион байгуулах журам”, “Багш оюутны суралцахуйн үр дүнг үнэлэх журам”, “Оюутан бүрээр гарц үр дүнгийн үнэлгээ хийх удирдамж”-ийн дагуу хөтөлбөрийн болон хичээлийн суралцахуйн үр дүнг хөтөлбөр бүрээр боловсруулан гаргасан.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Монгол улсын БСШУЯ-ны холбогдох хууль, журам болон СЭЗИС-ийн ректорын тушаалын дагуу бодлогын баримт бичгүүдийг тулгуурлан хөтөлбөрийг тасралгүй сайжруулсаар байна.
- Сургалтын үр дүнд суралцагч эзэмшин төгсөх цогц чадамжийг тодорхойлсон “Маркетинг” хөтөлбөрийн зорилго (PEO), хөтөлбөр (PLO), хичээлийн (CLO) суралцахуйн үр дүнгийн матрицийг боловсруулж инфосистемдээ холбосон байна.

#### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг (PLO) сайжруулан шинэчлэхдээ хөтөлбөрөөр суралцагчдын зөөлөн ур чадварыг нэмэгдүүлэхэд анхаарах
- Нийгмийн, танилцах, мэргэжлийн дадлагуудын уялдаа холбоог сайжруулж, ажил олгогчидтой хамтран дадлагын хөтөлбөрийг боловсруулах

#### **Зөвлөмж:**

- Зарим мэргэшүүлэх болон мэргэжлийн хичээлийн суралцахуйн үр дүнг (CLO) дахин шинэчлэхдээ төгсөгч болон ажил олгогчдын оролцоог нарийвчлан тусгах
- Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгийг тасралтгүй сайжруулсаар байгаа боловч багшийн програмын хөгжүүлэлтийг хийхдээ PLO болон CLO-н харагдацыг ойлгомжтой байдлаар өөрчлөх

### **1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## **Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа**

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

### **2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл**

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Мэргэжлийн хөтөлбөрийн сургалтын агуулга, арга зүй, үнэлгээний шинэчлэлийг Монгол улсын холбогдох хууль, тогтоомж, СЭЗИС-ийн дүрэм, журмын хүрээнд үндэслэн боловсруулсан.
- “Маркетинг” мэргэжлийн тодорхойлолтод онолын мэдлэг олгохоос гадна практик мэдлэг, ур чадварыг олгох зорилготой кейс сургалт, бизнесийн болон мэргэжлийн дадлага, хөгжлийн семинар зэргийг оруулсан ба энэ нь бие даасан хичээлийн хэлбэртэй, тооцох кредиттэйгээр тусгагдсан.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага**

- “Маркетинг” хөтөлбөрийн сургалтын агуулга, арга зүй, үнэлгээний шинэчлэлтүүд тасралтгүй сайжирсаар байна.
- Хөтөлбөр дэх хичээлийн хэлбэр нь онол, практикийн зохистой харьцааг хангасан.
- Хөгжлийн семинар болон бизнесийн байгууллагатай танилцах аялал зэрэг бусдаас ялгарах хөтөлбөртэй.
- Нийт хичээлүүдийн 95 орчим хувь нь өөр хоорондоо шууд уялдаа холбоотой.
- Суралцагчийн цагийн ачааллыг тогтмол судалж, тасралтгүй сайжруулалт хийсээр байна.

### **Анхаарах асуудал:**

- СЭЗИС нь бусад дотоодын хөтөлбөрүүдээс ялгарах онцлог талууд байгаа боловч хөтөлбөрт тусгагдсан байдал нь бодит байдлаасаа дутагдалтай байгааг анхаарах
- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг сайжруулан шинэчлэхэд төгсөгчийн ачаалал даах ур чадвар, сэтгэл зүйгээ тогтвортой байлгах хандлагыг хөгжүүлэхэд анхаарах

### **Зөвлөмж:**

- СЭЗИС-ийн “Маркетинг” хөтөлбөрийн онцлог ялгаатай тал нь энтрепренер их сургууль болох зорилго болон хөтөлбөрийн багийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чиглэлтэй уялдуулан сургалтын хөтөлбөрийн агуулгыг тогтвортой маркетинг, нейромаркетинг, дижитал маркетинг, маркетингийн судалгаа, шинжилгээ гэсэн чиглэлд хөтөлбөрийн сайжруулалт хөгжүүлэлтийг хийх
- Хичээлийн уялдаа холбоо хийсэн нь сургуулийн хувьд онцлогтой ч хөтөлбөрийн модыг чухал хичээлээс салбарлуулах бус ерөнхий эрдэм, мэргэжлийн, мэргэшүүлэх байдлаар нь хийх

## **2.2 Сургалтын арга зүй**

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологид тулгуурлан холбогдох дүрэм, журмуудын дагуу сайжруулан шинэчлэгдсээр байна.
- Цахим сургалтыг зохион байгуулах журам болон цахим сургалт зохион байгуулах гарын авлагыг тусгайлан боловсруулж, бүх багш нарт сургалт өрнүүлж, цахим талбарт хөгжүүлэлтийг хийсээр байна.
- Сургалтын арга зүйг сайжруулахад багш болон хичээлийн суралцахуйн үр дүнгийн судалгааг хийж, түүний үр дүнгээр сайжруулалтыг хийж байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Суралцахуйн 4 тулгуур зарчим ба сурган заах аргазүйн 6 зарчмыг хэрэгжүүлж байна.



- Хөтөлбөрийн хүрээнд 10 төрлийн аргазүй, 14 төрлийн сургалтын хэлбэрийг ашиглаж байна.
- Сургалтын аргазүйг сайжруулахад тогтмол хичээлийн гарц үр дүнгийн судалгааг хийдэг ба дараагийн хөтөлбөр сайжруулалтад ашигладаг.
- Сургалтын хөтөлбөрт хичээл зааж буй бүх багш нарт дижитал орчинд ажиллах заах арга зүй бүрдсэн байна.

#### **Анхаарах асуудал:**

- Сургалтын арга зүйг хэрэгжүүлж буй байдлын гүйцэтгэлийг үнэлэхдээ түүврээр бус мэргэжлийн хөтөлбөрт хамаарах бүхий л хичээлүүдээр хийх

#### **Зөвлөмж:**

- Багш нарын сургалтын заах арга зүйг сайжруулахад мэргэжлийн онцлогтой холбоотойгоор шинэчлэх, сургалтад хамруулах

### **2.3 Суралцагчийн үнэлгээ**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Багш, оюутны суралцахуйн үр дүнг үнэлэх журам, Бакалаврын сургалт зохион байгуулах журамд тулгуурлан суралцагчийн үнэлгээг хийдэг.
- Сургуулийн инфосистемд хичээлийн төлөвлөгөө, үйл явц, үнэлгээг хэрхэн хийх талаар тодорхой тусгагдсан байдаг.
- Хичээлийн төлөвлөгөөнд тусгагдсан даалгавар, бие даалт, семинар, шалгалт зэргийг үнэлэхдээ хийх ажлын ач холбогдол, агуулга, оюутны оролцоо зэргийг харгалзан үнэлгээний рубриkyг ашигладаг.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Суралцагчийн үнэлгээ хөтөлбөрийн болон хичээлийн гарц үр дүнгийн үнэлгээ, хөндлөнгийн үнэлгээ (peregrine test), нэгдсэн шалгалт зэрэг үнэлгээнүүдээс бүрддэг.
- Суралцагчийн сурлагын ахиц амжилтад анализ хийдэг байдал нь шууд ба шууд бус үнэлгээний аргуудаар хийж тогтмолжсон.

#### **Анхаарах асуудал:**

- Сургалтын үр дүнг үнэлэх (оюутан, төгсөгч, ажил олгогчийн сэтгэл ханамж) олон талт үнэлгээний системийг хэрэгжүүлдэг боловч хийгдсэн судалгааны үр дүнгүүдийг нэгдсэн байдлаар өөр хооронд нь уялдуулан сайжруулах

#### **2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### **Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц**

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

#### **3.1 Сургалтын орчин**

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- СЭЗИС нь хоорондоо холбоотой хичээл сургалтын 3 байраас бүрддэг. Галын аюулгүй байдал, камер хяналтын систем, мэдээллийн терминал зэргийг хүрэлцээтэй байршуулсан байна.
- Нэг оюутанд ногдох талбай бакалаврын хөтөлбөрийн өдрийн ангид 2,1, оройн ангид 5,8 метр квадрат байна. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын тусгай хэрэгцээнд зориулсан орц, гарцтай. Хөдөө орон нутаг болон гадаад оюутнуудад зориулсан 240 оюутан амьдрах хүчин чадалтай оюутны байртай.
- Сургалт явуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, лаборатори, цахим видео хурал, хичээлийн анги танхимаар иж бүрэн хангагдсан.
- “Аксиом Инк” ХХК-тай хамтран “Аксиом Нейролаб” ХХК-ийг байгуулан, маркетингийн чиглэлээр хэрэглэгчийн зан төлөв, шийдвэр гаргалтыг судлах судалгааны ажлуудыг амжилттай хийж, маркетингийн судалгаа ба шинжилгээ, джитал маркетинг, нейромаркетингийн хичээлүүдэд ашиглаж байна.
- Сүүлийн 5 жилд хөтөлбөрийн үйл ажиллагаатай холбоотой нийт 7 төрлийн 150 орчим санал, гомдлыг шийдвэрлэсэн. Нийт санал гомдлын 60 орчим хувийг сургалтын орчин /халаалт, цахилгаан, дулаан, цэвэрлэгээ, үйлчилгээ/-той холбоотой санал эзэлжээ.

### Шалгуурыг хангасан байдал: **Хэсэгчлэн хангасан**

#### Онцлог зүйл/Туршлага:

- Олон Улсын зэрэглэлийн шалгалт авдаг, иж бүрэн тоноглогдсон “Тестийн” төв, мөн Орос хэл судлалын төв шинээр байгуулан ажиллаж байна.
- СЭЗИС-ийн багш, ажилчдын хүүхдүүдэд зориулсан бүрэн дунд сургууль, цэцэрлэгтэй. Тэдгээрт 34 багш, сурган хүмүүжүүлэгч ажилладаг. Багш, ажилчдын сэтгэл ханамж өндөр байна.

#### Анхаарах асуудал:

- Маркетингийн мэргэжлийн 5 хичээл, оюуны өмчийн гэрчилгээтэй. Бусад бүх хичээлүүдийг оюуны өмчийн гэрчилгээтэй болгож, баталгаажуулах
- Джитал технологи эрчимтэй хөгжсөнөөр мэдээллийн аюулгүй байдалд сөрөг нөлөөтэй. Орчин үеийн мэдээллийн аюулгүй байдлыг илүү хангах боломжтой системүүдийг судлан нэвтрүүлэх

#### Зөвлөмж:

- Сургуулийн “Платформ-Хөгжлийн алба”-ны хэрэгжүүлж буй ажлын амжилт бүтээлийг сурталчлах, бусдад тэргүүн туршлага болгох
- Өөрсдийн онлайн сургалт хөгжүүлсэн туршлагыг гадаад, дотоодын цахим сургалтаар суралцах сонирхолтой хэрэглэгчдэд хүргэх, сурталчлах
- Олон улсын стандартад нийцсэн боловсролын үйлчилгээг үзүүлэхийн тулд Чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх. СЭЗИС-ийн “Чанарын бодлого”-ыг боловруулах

### 3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

#### Илрэл нотолгоо:

- Сургуулийн “Стратеги төлөвлөгөө 2021-2031”-д Орчны өөрчлөлттэй зохицож тасралтгүй хөгждөг уян хатан, нээлттэй институт байх зорилгын хүрээнд Мэдээллийн системийн Ре-инженеринг маш амжилттай хэрэгжиж байна.
- Джитал орчинг бүрдүүлэх, системийн шинэчлэлийг 2009 оноос хойш эрчимтэй сайжруулсаар ирсэн бөгөөд сургалтын хэрэглэгдэхүүн, програм хангамж, хичээлийн хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан.
- Нейромаркетингийн шинэлэг “EEG”, “EVETRACK”, “GSR+POLYGRAPH TESTING”, “FACIAL EXPRESSION” судалгааны аргуудыг амжилттай нэвтрүүлсэн.

- СЭЗИС-ийн багш оюутнууд нейромаркетингийн зан төлөвийн судалгааны “АКСИОМ НЕЙРОЛАБ” компанитай хамтарч өргөн хүрээнд судалгаа хийж байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- СЭЗИС-ийн “Цахим оюутны”, “Цахим багшийн ” гарын авлага боловсруулсан.
- Заах арга зүйн онцлог шинж чанартай, дижитал орчинд ажиллах чадвартай, залуу хамт олон бүрдсэн.

#### **Анхаарах асуудал:**

- Олон нийтийн боловсролыг хөгжлүүлэхэд чиглэгдсэн контентүүд бүтээх, түгээх, санаачлагыг дэмжих тогтолцоог бүрдүүлэх
- Нейромаркетингийн судалгааны чанарыг олон улсад магадлан итгэмжлүүлэх

#### **Зөвлөмж:**

- СЭЗИС-ийн хэрэгжүүлж буй нийгмийн өөрчлөлт, шинэчлэлтийн үйл ажиллагааны үр нөлөөг олон улсад үнэлүүлэх
- СЭЗИС-ийн хэмжээнд жил бүрийн 10-р сарын 1-нд зохион байгуулагддаг “Багш, Оюутны тангараг өргөх” ёслолын үйл ажиллагааг нийтэд сурталчлах, түгээх

### **3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- СЭЗИС нь ном сурах бичгийн 5 фондтой, 615,3 метр квадрат талбайтай, 260 суудалтай, 7 уншлагын танхимтай.
- Номын сан 12 ажилтантай. Үүнээс Магистрын зэрэгтэй 4, бакалаврын зэрэгтэй 8 хүн оюутнуудад үйлчилж байна.
- Номын сан 67 000 номтой, 2021 оны байдлаар нийт номын 21,4% буюу 28 000 ном Маркетингийн мэргэжлийн ном сурах бичиг байна.
- Сүүлийн 5 жилд 6000 номоор баяжигдсан. EBSCO цахим номын сан ашиглах эрх нээгдсэн.
- 2015 оноос “Repository” оюутны судалгааны ажлын, бүтээлийн нэгдсэн сантай болсон. Бүтээлийн санд нийт 1824 бүтээл оруулсан байгаагаас 50 гаруй хувь нь бизнесийн болон маркетингийн мэргэжлийн оюутнуудын бүтээл байна.
- СЭЗИС нь EBSCO Discovery service лавлагаа мэдээллийн нэгдсэн хайлтын системийн үйлчилгээг зөвхөн тус сургуулийн багш оюутнаар хязгаарлахгүй, 24 цагийн турш олон нийтэд нээлттэйгээр ашиглах боломжийг Монгол улсын хэмжээнд анх удаа олгосон. Тус мэдээллийн санд жилд дунджаар 2 сая гаруй хандалт хийгдсэн байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- 2021 оноос EBSCO complete-н эрхийг авснаар оюутнууд гадаадын их дээд сургуулиуд, судалгааны байгууллагуудын нийтлэл, бүтээлүүдээс ишлэл авах боломж бүрдсэн.
- СЭЗИС-н оюутнууд АНУ-н Харвардын бизнесийн сургуулийн 57-н видео хичээлүүдийг үнэгүй авах боломжоор хангагдсан.

#### **Анхаарах асуудал:**

- Сургуулийн номын сангийн электрон каталогийн хандалтын тоо 2020 онд буурсан учир шалтгааныг судлах

- Цахим хичээл, ном сурах бичиг, хичээлийн материал зэргийн аюулгүй байдлыг хангах тогтолцоо бүрэн бэхжээгүй.

**Зөвлөмж:**

- Найдвартай, аюулгүй байдлыг бүрэн хангах технологиудыг судалж сургалтын системийн эрүүл байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэх
- Монгол, Орос хэл дээрх ном сурах бичиг, цахим ном сурах бичгийн тоог нэмэгдүүлэх, сурталчилах

**3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

**Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

**4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа**

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Маркетинг хөтөлбөрийг хөгжүүлэх, сургалтын чанарыг дээшлүүлэхтэй холбоотой шийдвэрүүдийг холбогдох дүрэм журмын дагуу хэрэгжүүлдэг. Үйл ажиллагаагаа зохицуулах эрх зүйн баримт бичгүүд бүрдсэн байна.
- Сургуулийн ТУЗ-д гүйцэтгэх удирдлага, хувь нийлүүлэгч, багш, оюутны төлөөлөл багтдаг учраас хөтөлбөрийг сайжруулахад тэдний саналыг тусгах боломжтой. /Багш нарын дундаас сенатын гишүүнийг сонгож удирдах зөвлөлд ажиллуулдаг/
- СЭЗИС-ийн стратегийн 2021-2031 оны төлөвлөгөө, дунд хугацааны 2021-2024 оны төлөвлөгөөнүүдэд үндэслэн жил бүрийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлдэг.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Сургуулийн хэмжээнд мэдээллийн 4 системийг /MOODLE, Infosys, UFE app, E-office/ ашиглаж, түүнийг улам сайжруулан ажиллаж байгаа нь Дижитал сургууль болох зорилготой, Axon Neiro & human behavior компанийг байгуулан хамтарч ажиллаж байгаа нь энтрепренер сургууль болох зорилготой тус тус уялдаж байна.
- Багш нараас сенатын төлөөллийг сонгож сургуулийн удирдах зөвлөлд ажиллуулдаг болсноор багш нарын дуу хоолойг удирдлагад хүргэхэд тус дөхөм үзүүлж байгаа

**Зөвлөмж:**

- СЭЗИС-ийн сургалтын үйл ажиллагаанд тохирох мэдээллийн аюулгүй байдлыг хангах, ачаалал даах, хэмнэлттэй технологийг тасралтгүй нэвтрүүлж сайжруулах

**4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Өнөөгийн байдлаар СЭЗИС нь Хятадын 15, ОХУ-ын 14 болон бусад /АНУ, Канад, Европын/ сургууль, судалгааны төв, байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ, санамж бичигт байгуулан ажиллаж, гадаад харилцаагаа өргөжүүлсэн. Мөн дотоодын 50 гаруй бизнесийн байгууллага болон ТББ, мэргэжлийн холбоодтой хамтран ажилладаг. Одоогоор 24 байгууллага нь идэвхтэй үйл ажиллагаатай байна. АПУ-тай байгуулсан гэрээний хүрээнд профессорын тэтгэлгийг /10,0 сая төгрөг/ олгодог болж байгаа.
- Дотоодын хамтын ажиллагааг Платформ түншлэлийн алба, гадаадын хамтын ажиллагааг Инноваци хөгжлийн газар хариуцан зохицуулдаг.
- Маркетинг хөтөлбөрийн багш нар сүүлийн 5 жилд дотоодын 10 байгууллагатай хамтран 23 захиалгат ажил, төсөл хэрэгжүүлж, нийт 295 оюутан оролцуулсан ба үр дүнг сургалтын материал болгон ашигладаг.
- 2015 оноос эхлэн нийгэмд чиглэсэн үйл ажиллагаануудыг зохион байгуулсан. Тухайлбал, Монголын маркетингийн холбоотой хамтран нийгмийн маркетингийн форум, 2018 онд “Хонгор үрдээ 20 минут” кампанит ажил зэргийг зохион байгуулсан.
- Маркетингийн хөтөлбөрөөр төгсөгчдийн холбоог 2019 оноос шинээр байгуулж, багш төгсөгчдийн хамтарсан уулзалтыг 2020 онд зохион байгуулсан.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Нийгэм рүү чиглэсэн олон үйл ажиллагааг санаачлан зохион байгуулдаг.
- Хамтын ажиллагаагаа анги танхим тохижуулах, оюутнуудыг дадлага хийлгэх, тэтгэлэгт хамруулах, тэмцээн уралдааныг ивээн тэтгэх, захиалгат диплом бичүүлэх зэрэг чиглэлээр улам бүр өргөжүүлж байна.

#### **Анхаарах асуудал:**

- Гадаад, дотоодын солилцооны хөтөлбөрүүдэд маркетинг хөтөлбөрийн багш, оюутнууд төдийлэн хамрагддаггүй
- Төгсөгчдийн давтан сургалтанд хамруулах богино хугацааны модулиуд бий

#### **Зөвлөмж:**

- Маркетинг хөтөлбөрийн багш нарыг солилцооны тэтгэлгээр докторын сургалтанд хамруулах, хамтран удирдах

### **4.3 Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Жил бүр тэнхим, нэгжийн жилийн төсвийн саналыг захиргаа хүний нөөцийн алба болон эдийн засаг, санхүүгийн албанд хүргүүлдэг. Түүний дагуу орлого, зарцуулалт, нэг суралцагчид ноогдох өртөг зардал зэргийг тооцож, сургуулийн нэгдсэн төсвийг боловсруулан удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж баталдаг.
- Сүүлийн жилүүдэд хөтөлбөр, нэгжийн орлого буурч, зардал өсөх хандлагатай болсон нь улсын хэмжээнд элсэгчдийн тоо буурсан, ковидын нөлөө, цалин нэмсэн зэрэг шалтгаантай холбоотой байна.
- 2020 онд багш, ажилчдын цалинг 30 хүртэл хувиар нэмсэн төдийгүй багшийн хөгжлийг дэмжих зорилгоор нэг хичээлийн жилд 100,0 сая орчим төгрөгийг түүнд зориулдаг болсон.
- Багш ажилчдын нийгмийн арга хэмжээнд зориулсан зардал өсч байгаа нь түүнд анхаарал хандуулж байгааг харуулж байна.

- СЭЗИС-ийн нийт орлогын дийлэнх хэсэг нь сургалтын төлбөрөөс бүрддэг ба БУТ түүний 13 орчим хувийг бүрдүүлдэг.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- Багшийн хөгжлийг дэмжихэд зориулж төсөв батлан ажилладаг болсон нь давуу талтай.

##### **Анхаарах асуудал:**

- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зардал буурах хандлагатай болсныг анхаарах /ковидын нөлөө байж болно./

##### **Зөвлөмж:**

- Тэнхим, хөтөлбөрийг орлогын өөр эх үүсвэртэй болгох, хөшүүрэг, дэмжлэг үзүүлэхэд удирдлагын зүгээс анхаарч, багш нарын санал санаачлагыг дэмжих

#### **4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

##### **Илрэл нотолгоо:**

- Жил бүр ажлын байрны үзэсгэлэнг зохион байгуулж ажилладаг. Энэ үеэр хөдөлмөрийн зах зээлийн тандах судалгааг хийдэг.
- Мөн оюутанд үйлчлэх төвөөс тус сургуулийн төгсөгчидтэй хамтран ажлын байрны үзэсгэлэн /Job Fair/-г зохион байгуулж, ажил олгогчдын хэрэгцээ, сонирхол, шаардлагыг ойлгуулах, мэдээлэл өгөхөд анхаарч байна.
- Хөтөлбөр нь социал медиа сувгууд /ufe.edu.mn сайт, Facebook, Twitter, Youtube, Instagram, LinkedIn/-ыг өргөн ашиглаж, үйл ажиллагаагаа сурталчилдаг ба түүнд анализ хийдэг болсон.
- Маркетингийн мэргэжлийг сурталчилан таниулах үйл ажиллагааг хэрэгжүүлснээр тухайн хөтөлбөрт элсэгчдийн тоо нэмэгдэж 2 бүлэгт элсэлт авдаг болсон.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- Мэдээллийн олон суваг ашиглаж байгаа нь давуу талтай.

##### **Анхаарах асуудал:**

- Мэдээллийн сувгуудаар дамжуулан хүргэж буй контентуудыг илүү сонирхолтой хэлбэрээр, тодорхой давтамжтайгаар тогтмол хүргэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлэхэд анхаарах

##### **Зөвлөмж:**

- Маркетингийн мэргэжлийн хөтөлбөрийг сурталчлан таниулах фейсбүүк хаяг нээх

#### **4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

##### **Илрэл нотолгоо:**

- Үйл ажиллагаагаа дотоод, гадаад сувгуудаар олон нийтэд ил тод мэдээлдэг.
- Мэдээлэл постууд 2019 оноос нэлээд нэмэгдсэн байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**



### **Онцлог зүйл/Туршлага:**

- Олон нийтэд мэдээлэл хүргэх үйл ажиллагаа тогтмолжсон, мэдээллийн олон эх үүсвэрийг ашигладаг зэрэг нь давуу талтай.

### **Зөвлөмж:**

- Олон нийтийн мэдээлэл харилцааг тогтмол хариуцан гүйцэтгэх ажлыг тухайн нэг хүнд даалгаж ажиллуулах

### **4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## **Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа**

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

### **5.1. Суралцагч сонгох, элсүүлэх**

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- СЭЗИС-ийн оюутан элсүүлэх журамд зааснаар ерөнхий шалгалтын үнэлгээнээс гадна нэмэлт “Авьяас чадвар болон ур чадвар”-н амжилтын нотолгоо, IQ, EQ, ёс зүйн төлөвшлийн тест, Эссэ зэргээр нэмэлт оноо авах боломжийг бүрдүүлсэн байна.
- Шинэ элсэгчдэд зориулсан “Чиглүүлэх сургалт”-г жил бүр зохион байгуулж хэвшсэн.
- Элсэгчдэд зориулсан “Гарын авлага”-г боловсруулж инфосистемд байршуулсан.
- 2020 оноос эхлэн элсэгчдэд зориулсан мэргэжил сурталчлах, мэргэжлийн онцлогийн талаар танилцуулах Poolcast podcast-г маркетингийн мэргэжлийн багш нар санаачилж хэрэгжүүлсэн байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- “Чиглүүлэх сургалт”-н хөтөлбөр боловсруулахад сургуулийн бүх алба, хэлтэс нэгжүүд оролцож сургалтын төлөвлөгөөг батлуулдаг.
- Инфосистемд байршуулсан “Оюутны гарын авлага” –д СЭЗИС-ийн бүтэц зохион байгуулалт, бакалаврын сургалтын журам, оюутны дотуур байр, эрүүл мэндийн үйлчилгээ, оюутны холбоо, оюутны клубүүд, эрдмийн ажлын бичилт хийх стандарт зэрэг мэдээллүүдийг оруулснаараа онцлогтой.

### **Анхаарах асуудал:**

- СЭЗИС-ийн “Стратеги төлөвлөгөө 2021-2031”-д батлагдсан Алсын хараа, Эрхэм зорилго, Үнэт зүйлсийг Шинэчлэн байршуулах (*Одоогоор А байрны 1-р давхарт СЭЗДС-ийн хуучин Алсын хараа, эрхэм зорилго хадаатай байна.*)
- Багш, оюутны “тангараг”-н үгийг үзэгдэх орчинд ил байрлуулж, сурталчилах (*одоогоор сургуулийн музей дотор байгаа*)

### **Зөвлөмж:**

- Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчдын дунд зохион байгуулдаг “Шинэ үеийн маркетер-2019” маркетингийн олимпиадыг уламжлал болгон зохион байгуулах
- Сургуулийн бичиг баримтуудад “төгөлдөршил” гэдэг үг, нэр томъёо олон орсон байна. Амьдрал дээр төгс, төгөлдөр зүйл огт үгүй, тэр тусмаа судалгаа,

сургалтын төгөлдөршил гэж байж болохгүй. Тасралтгүй шинэчлэгдэж сайжруулалт хийгдэж байх ёстой гэж үздэг. (Сургуулийн стратеги төлөвлөгөө 2021-2031. Үнэт зүйлст орсон байна.)

## **5.2. Зөвлөн туслах үйлчилгээ**

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Шинэ оюутанд зориулсан "Чиглүүлэх сургалт" онлайн-аар явагддаг. Заавал судлах "Тооцов" үнэлгээтэй хичээл. Энэ хичээлээр дижитал, энтрепренер их сургуульд орж ирснээ мэдэрдэг.
- Хөтөлбөрийн хөгжүүлэлтэд тэнхмийн нийт багш нарын идэвх оролцоо маш сайн.
- СЭЗИС-н Сургалтын алба нь "Оюутны хөгжлийн бодлого"-г боловсруулж хэрэгжүүлдэг.
- "Сэтгэл зүйн" сургалт онлайн-аар явагддаг. Энэ хичээлийг сонгон суралцдаг.
- Бакалаврын сургалтын албаны үйл ажиллагааны үндсэн чиглэл маш өргөн хүрээг хамардаг. Үүнд:
  1. Сургалт семинар, уулзалт, ярилцлага, зөвлөгөө
  2. Ажлын байр сурталчилах, ажилд авах
  3. Урлаг, соёл спортын наадам уралдаан тэмцээн
  4. Олон нийтийн ажил
  5. Мэдээлэл хүргэх
  6. Оюутны сонирхлын клуб

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Нийгмийн өмнө хариуцлагатай иргэн болж төлөвших 4 үе шатаар Оюутны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлдэг. 1-р курст Өөрийгөө хөгжүүлэх, 2-р курст Бүлэгт хамрагдах, 3-р курст Сайн дураар нийгэмд үйлчлэх, 4-р курст Зохион байгуулах гэсэн үе шатуудыг дамжих ажлыг БСА-ны мэргэжилтэн хариуцан ажилладаг.
- БСА нь "Оюутан хүний үүрэг хариуцлага, суралцах үйл ажиллагааны онцлог"-н талаар мэргэжлийн зөвлөхүүд болон төгсөгчдын оролцоотойгоор видео хэлэлцүүлэг явуулах, вэб сайтад байнга байршуулах ажлыг гүйцэтгэдэг.

### **Анхаарах асуудал:**

- Бакалаврын сургалтын албаны мэргэжилтний ажил үүргийн хуваарьт урлаг, соёл, спортын наадам, уралдаан тэмцээн зохион байгуулах, оюутны сонирхлын клуб зэрэгтэй холбоотой асуудлыг зохион байгуулах шаардлагагүй гэж үзэж байна.
- Ангийн зөвлөх багш, БСА-ны туслах, тэнхмийн туслах ажилтан, оюутны дотуур байрны багш зэрэг ажилтнуудын ажил үүргийн хуваарьт давхцал байгааг судлах

### **Зөвлөмж:**

- СЭЗИС-ийн төгсөгчдөөс төрсөн "Мөнгөн ирвэс" бөгжний эздийг сурталчилах, тэдний ажил, амьдралын туршлага судлах, оюутнуудад "обзор лекц" уншуулах
- Нийгмийн дадлага, мэргэжлийн дадлага хичээлүүдийн бодит үр дүнгүүдийг танилцуулах, сурталчлах ажлыг тогтмолжуулах
- Дадлагын ажлын тайланг гараар бичүүлэх, энэ нь албан бичиг боловсруулах дадал эзэмшүүлэх зорилго агуулна.

## **5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшуулал**

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

### **Илрэл нотолгоо:**



- Оюутны бие даалтын ажлын хүрээнд зах зээлийн судалгаа, брэндийн судалгаа, өрсөлдөгчийн судалгаа, хэрэглэгчийн зан төлвийн судалгаа, идэвхжүүлэлтийн судалгаа, борлуулалтын сувгийн судалгаа, үнийн харьцуулсан судалгаа зэргийг өргөн хүрээнд хийж нийгмийн амьдралд оролцдог.
- Оюутнуудыг Монголын кейсүүд дээр их ажиллуулж, дадлага туршлага эзэмшүүлдэг.
- Маркетингийн мэргэжлийн багш нар захиалгат ажил, төслийн багт оюутнуудыг оруулах байдлаар дэмжиж тусалдаг.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Сургуулийн оюутны холбооны дэргэд сайн дураараа эвлэлдэн нэгдсэн тодорхой үүрэг зориулалт бүхий оюутны 24 клуб үйл ажиллагаагаа идэвхтэй явуулж байна. Эдгээрийг үйл ажиллагааны чиглэлээр нь ангилвал, маркетингийн мэргэжлийн чиглэлээр 8, нийгэм соёл, олон нийтийн чиглэлээр 10, урлаг уран сайхны чиглэлээр 3, спортын чиглэлээр 3 клуб ажиллаж байна. Нийт 600 орчим оюутнууд хамрагддаг бөгөөд сайн дурын үйл ажиллагаанд зориулж төсөв баталдаг. Төсвийн зарцуулалтын судалгаанаас харахад жил бүр үйл ажиллагааны зардал өсөн нэмэгдэж байна.
- Үндэсний хэмжээнд зохион байгуулагддаг Маркетингийн мэргэжлийн олимпиадад жил бүр амжилттай оролцож хүчтэй өрсөлдөг байж чаддаг. Нэр хүндтэй, уламжлал сайн.
- Мэргэжлийн сургалтын хөтөлбөрт оюутнууд 1-р курстээ “Нийгмийн дадлага” хийж хамгаалдаг. Нийгмийн дадлагын хүрээнд олж авсан төлөвшил, ухааралд оюутнууд сэтгэл ханамж өндөр байна.
- Маркетингийн мэргэжлийн багш нарын санаачлагаар “Мөрөөдөлтэй нийгэм-Нийгмийн Маркетингийн Институт” ТББ байгуулж, нийгмийн маркетингийн компани ажлуудыг амжилттай зохион байгуулсан байна.
- Сургуулийн оюутнуудад зориулсан “Инфосис” систем дээр бизнесийн байгууллагуудаас ирүүлсэн ажлын зарыг байршуулж, зуучилдаг.
- Маркетингийн мэргэжлийн багш оюутнууд хамтран 10 гаруй байгууллагын 20 орчим захиалгат судалгааны ажлуудад 295 оюутныг оролцуулж ажлуулсан.
- Ректорын нэрэмжит тэтгэлгийг 1261 оюутан авсан бөгөөд үүнээс 55 нь Маркетингийн мэргэжлийн оюутан байна.

#### **Анхаарах асуудал:**

- Сайн дурын клубуудын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, идэвхжүүлэх
- СЭЗИС-н оюутнуудын дунд “Үндэсний дүр бүтээх уралдаан зарлаж, “Мазалай”, “Цоохор ирвэс”, “Бөхөн”-г онцлон тодруулсан. Уралдааны үр дүн, ач холбогдлыг нийтэд зарлаж, сурталчилах ажлуудыг зохион байгуулах

#### **Зөвлөмж:**

- “Ирээдүйн элсэгчдэд зориулсан” аппикэйшн гаргасан. Түүний хэрэглээг идэвхжүүлэх, сурталчилах, олон нийтэд түгээх
- Дотоодын уралдаан тэмцээн, олимпиадад оролцсон туршлага дээрээ үндэслэн олон улсын маркетингийн мэргэжлийн уралдаан тэмцээнд оюутнуудаа оролцуулж, эх орныхоо өрсөлдөх чадварт үнэ цэнтэй хувь нэмэр оруулах

#### **5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Магадлан итгэмжлэгдсэн гадаад, дотоодын их, дээд сургууль коллежид голч оноо 3.00-с багагүй дүнтэй суралцсан суралцагч СЭЗИС-д шилжин суралцах боломжтой. СЭЗИС-н босго онооны 85 хувийг хангасан байх, тус сургуульд суралцах багц цаг нь сургалтын төлөвлөгөөний нийт багц цагийн 60%-иас багагүй байх зэрэг шаардлагуудыг тавьдаг байна.
- Шилжин суралцах хүсэлтийг БСА хүлээн авч, суралцахуйн хүрсэн үр дүнг дүйцүүлэх нөхцөлүүдээр судлаж, захиралын тушаалаар шийдвэрлэж байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Шилжин ирсэн оюутан бүтэн өнчин, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй, ар гэр нь амжиргааны баталгаажих түвшингөөс доогуур орлогтой бол албан ёсны батлах, баримт бичгийг үндэслэн сургалтын төлбөрийг бууруулдаг.

#### **Анхаарах асуудал:**

- Шилжин ирсэн оюутан тухайн улиралын сургалтын төлбөрөөс гадна “шилжилтийн төлбөр” төлдөг. Энэ нь ямар учир шалтгаантай, ямар дүрэм журмаар зохицуулагддаг болохыг тодруулах

#### **Зөвлөмж:**

- Шинээр шилжин ирсэн оюутанд “Тангараг өргөх”, “Чиглүүлэх сургалт”, “Оюутны хөгжлийн бодлого”, “CE BADGE” хөтөлбөртэй танилцаж судлах, нөхөж суралцах талаар тусгай удирдамж гаргаж хэрэгжүүлэх шаардлагатай.

### **5.5. Төгсөлтийн баримт бичиг**

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

#### **Илрэл нотолгоо:**

- СЭЗИС-н төгсөгчдөд олгох Бакалаврын дипломыг крилл, уйгаржин, англи хэл дээр үнэт цаасаар хэвлэн олгодог.
- СЭЗИС-н диплом нь өндөр нэр хүндтэй, өрсөлдөх чадвартай албан баримт бичиг мөн.
- СЭЗИС нь “Chatbot blog”- той. Энэ нь тодорхой үйлдлүүдийг хэрэглэгчтэй харилцах зорилготой мессэж програм хангамж учраас оюутны төгсөлтийн ажлыг энэ програмд оруулж, ажил олгогчдод сурталчлах ажлыг зохион байгуулж байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөдөлмөрийн зах зээл дээр СЭЗИС-г төгсөгчид мэдрэмжтэй, сэтгэлгээний хурдтай гэж үнэлэгдэж байна. Ажил олгогчид, төгсөгчид БМИҮЗ-н шинжээчидтэй уулзах ярилцлага, хэлэцүүлэгт сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлсэн.

#### **Анхаарах асуудал:**

- “block chain” програмыг ашиглах заавар, удирдамжийг боловсруулж, ажил олгогчдод өргөн сурталчлах, Монгол улсын хууль, журамд нийцүүлэх шаардлагатай.

#### **Зөвлөмж:**

- СЭЗИС-н төгсөгч оюутнуудын ажил амьдралын бэрхшээлийг боломж болгон хувиргах чадвар, ямар бизнес хийхээ, хаана хүрэхээ, тийшээ хэрхэн яаж хүрэхээ тодорхойлж чадах чадварт илүү анхаарч ажиллавал сургуулийн эрхэм зорилгод хүрнэ. Их дээд сургууль төгсөгч иргэнд тууштай, тодорхой зорилготой, тогтвор

сууршилтай байх чадвар дутагдаж байгааг ажил олгогчид тодорхой хэлж байна. Энэ чадварыг эзэмшүүлэх чиглэлээр үр дүнтэй ажлуудыг зохион байгуулах

## 5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

### Шалгуур 6. Багшлах бүрэлдэхүүн

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

#### 6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

#### Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүний нөөцийн бодлого, албан тушаалын зэрэглэл болон урамшууллын асуудлыг холбогдох хууль тогтоомж болон хөдөлмөрийн дотоод дүрэм, журмаар зохицуулдаг.
- Багш, суралцагчдын тооны харьцаа зохистой түвшинд байгааг тайланд хийгдсэн судалгааны үр дүн харуулж байна. /Нэг багшид 18 оюутан ногдож байна/
- Өнөөгийн байдлаар Маркетинг хөтөлбөрт 9 багш ажиллаж байгаагийн дотор докторын зэрэгтэй багш байхгүй байгаа нь гол сул тал болж байна. БУТ-д одоо 4 багшийн орон тоо дутагдалтай байна.
- Багш нарын цагийн ачааллыг тооцсон судалгаанаас харвал А, В, С цагийн норм ерөнхийдөө /сүүлийн 5 жилд А цаг 140-200%%, В цаг 200%-с дээш, С цаг 140-185% тус тус гүйцэтгэлтэй/ байнга давж биелдэг.
- Багш нарт олгодог шагнал, урамшууллын үйл ажиллагаа тогтворжсон.
- Багш нар багаар ажиллаж мэргэжлийн хичээлүүдийг заадаг.

#### Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

#### Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн багшлах бүрэлдэхүүн ерөнхийдөө залуучуудаас бүрдсэн нь давуу талтай.
- Маркетинг хөтөлбөрийн ахлагчийг багш нар жил жилээр ээлжлэн хийдэг нь багш нар туршлагажих, ачааллыг тэнцвэржүүлэх зэрэг ач холбогдолтой.
- Жил бүр ректорын нэрэмжит шагналыг 9 хүртэлх багш, ажилтанд олгодог. Сүүлийн жилүүдэд маркетингийн хөтөлбөрийн багш нараас энэ шагналд тогтмол хамрагдсан байна.

#### Анхаарах асуудал:

- Тэнхимийн багш нарын бүтцэд эзлэх докторын тоо /17,8%/ бага байгаад дүгнэлт хийх. Ялангуяа маркетингаар мэргэшсэн доктор зэрэгтэй багшийн тоог нэмэгдүүлэхэд анхаарах
- Багш нарт бүтээлийн чөлөө өгч доктор хамгаалахад нь түлхэц болох

#### Зөвлөмж:

- Гадаадын сургуулиудтай хамтарсан докторын хөтөлбөрт багш нарыг хамруулж, зэрэг хамгаалахад дэмжлэг үзүүлэх

#### 6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Хүний нөөцийн бодлогын баримт бичигт тусгасны дагуу багш, ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх ажлуудыг жил бүр зохион байгуулдаг.
- Багшийн хөгжлийн хөтөлбөр нь багш нарын тасралтгүй хөгжих нөхцөл боломжийг бүрдүүлж чадсан байна.
- Багш нарын ур чадвар, суралцах хэрэгцээг тодорхойлсон багшийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж ажилладаг болсноор сүүлийн 5 жилд нийт 14 чиглэлээр сургалт, семинар, хурлуудад хамрагдсан нь тайлангаас харагдаж байна.
- 2018 онд СЭЗИС-ийн ректорын тушаалаар “Багш, оюутны суралцахуйн үр дүнг үнэлэх журам” баталж, багшийн хөгжлийн төлөвлөгөөний загварыг боловсруулан /багшийн мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх, стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх гэсэн 2 чиглэлээр/ хэрэгжүүлж үнэлж байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Багшийн хөгжлийг дэмжих зорилгоор жилдээ нэг багшид 10,0 хүртэл сая төгрөгийг төсөвлөн зарцуулах эрхийг тэнхим, нэгжийн удирдлагад өгч хэрэгжүүлдэг болсон.
- Хичээлийн багуудыг ажиллуулдаг болсноор багш нар нэг нь нөгөөгөө нөхөж, сургалтын үйл ажиллагааг тасалдуулахгүй явуулах боломжийг бүрдүүлсэн.

#### **Анхаарах асуудал:**

- Багшийн хөгжлийг дэмжих зорилгоор багш нарыг олон сургалт, семинарт хамруулж байгаа хэдий ч багшийн заах арга зүйн чиглэлийн сургалтууд харьцангуй бага байна.

#### **Зөвлөмж:**

- Хичээлийн хамтлагууд хоорондоо туршлагаа хуваалцаж хэлэлцүүлдэг байвал зүгээр юм.

### **6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа**

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- БУТ-д ЭШ, судалгааны чиглэрээр төрөлжсөн 4 баг ажилладаг ба багш нар ЭШ, судалгааны ажлуудыг тогтмол гүйцэтгэж байна.
- Хөтөлбөрийн ЭШ-ний ажлын тэргүүлэх чиглэлийг Дижитал маркетинг, Энтрепренер, Тогтвортой ба нийгмийн маркетинг, E-commerce гэж тодорхойлсон.
- Маркетингийн багш нар жилд дунджаар 60-80 төсөлт ажлыг хийж гүйцэтгэдэг ба голдуу гадаад, дотоодын хамтарсан төсөл, судалгаануудыг хийдэг нь харагдсан.
- Багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих зорилгоор 2022 оноос эхлэн профессорын судалгааны суурь зардалд жил бүр 1,0-2,0 сая төгрөгийг олгохоор болсон нь сайн талтай байна.
- БУТ-ийн 45 хичээлээс маркетингийн мэргэжлийн 5 хичээлээр оюуны өмчийн эрх авсан.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Нейро маркетингийн судалгааны лабораторийг байгуулан, хамтарсан судалгаанууд хийж байгаа нь шинэлэг бөгөөд давуу талтай байв.

**Анхаарах асуудал:**

- Гадаадын нэр хүндтэй /peer review хийгддэг/ сэтгүүлүүдэд өгүүлэл хэвлүүлсэн багш нарын тоо бага байгаад анхаарч, дэмжиж ажиллах
- Багш нарын судалгааны ажил, нийтлэгдсэн бүтээлийн эшлэгдсэн тоог гаргадаг болох
- ЭШ-ний ажлын төсөв, зарцуулалт буурах хандлагатай байгаад дүгнэлт хийх

**Зөвлөмж:**

- Багш нарын эрдэм судлалын ажлын чанарыг сайжруулах

**6.4. Багшийн үнэлгээ**

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

**Илрэл нотолгоо:**

- Багшийн ажлын гүйцэтгэлийг холбогдох журмын дагуу удирдлагын мэдээллийн системд үнэлж дүгнэдэг.
- Багшийн өөрийн үнэлгээний тайланг дүгнэх тогтсон үзүүлэлтүүдийг мөрддөг.
- Хөндлөнгийн үнэлгээг удирдлага, оюутнуудаас авч дүгнэдэг.
- Багш бүр баримт материал бүхий хавтастай.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Анхаарах асуудал:**

- Багш нарын аттестатчилал хийгддэггүй. Хэрэв үүнийг хийвэл багшийн ажлыг хөндлөнгөөс үнэлэн харьцуулах, урамшуулах боломжтой

**Зөвлөмж:**

- Багш, ажилтнуудыг аттестатчилдаг болох

**6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

**Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт**

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

**7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт**

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

**Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтыг хангахдаа холбоотой Монгол улсын болон СЭЗИС-ийн холбогдох дүрэм, журмуудаар зохицуулан ажилладаг.
- Сургалтын үйл ажиллагааны чанарыг шинэ элсэгт элсүүлэхээс эхлээд мэргэжлийн зэрэгтэй төгсөгч болгох хүртэлх үйл явц нь сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр, агуулга, сургалтын ажлын зохион байгуулалт, багшийн сонголт, ур чадвар, багшийн хөгжил, сургалтын орчин зэрэг олон хүчин зүйлсээс хамаарч цогцоор нь сайжруулахын тулд сургуулийн эрхэм зорилго, зорилго, алсын хараа, алба нэгжүүдийн зорилго чиглэгдэж, холбогдох дүрэм журмуудад тусгалаа олж байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын бодлого, журам, хөтөлбөртэй.
- Сургалт, судалгааны үйл ажиллагааны чанарт тавих хяналт шинжилгээ, үнэлгээний процессийн зураглалын дагуу үйл ажиллагаа нь зохицуулагддаг.

### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтыг сайжруулахад багш нэг бүртэй удирдлагууд уулзаж ярилцдаг нь сайшаалтай боловч багш нарын сэтгэл ханамжийн судалгааг зайлшгүй хийж, тогтмолжуулах
- Боловсролын байгууллагын менежментийн тогтолцооны ISO9001, ISO21001 стандартуудыг судлах

### **Зөвлөмж:**

- Цаашид хөтөлбөрийн хэрэгжилтийг хянаж сайжруулахдаа оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад хэр нийцэж байгааг судалж үнэлэлт, дүгнэлт өгөх
- Оролцогч талуудын судалгааг хийж буй нь сайшаалтай боловч зөвхөн тоон үр дүнг гаргах бус, боловсруулалт хийж, уялдааг сайжруулах

## **7.2. Хөтөлбөрийн үр дүн**

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

### **Илрэл нотолгоо:**

- СЭЗИС нь бакалаврын төгсөгчдийнхөө төгсөлтийн дараах дүр зураг, ажил эрхлэлтийн судалгааг тогтмол чанартай хийж, судалгааны үр дүнд тулгуурлан сургалтын хөтөлбөр, оюутанд үзүүлэх үйлчилгээ, гадаад харилцаа, хамтын ажиллагаагаа сайжруулах зорилгоор 2013 оноос төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг тогтмол хийж байна.
- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг 2 шатлалтайгаар тухайн жилд төгссөн төгсөгчдийн 80-аас дээш хувийг тогтмол хамруулан судалдаг.
- Орчин үеийн хөгжлийн чиг хандлага, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, мэргэжилтэнд тавигдах шаардлага болон дээрх судалгаануудад үндэслэн хичээлийн хөтөлбөрийн агуулгыг хөгжүүлэн сайжруулж байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Төгсөгчдийн мөшгих судалгааг улиралд, жилд тогтмол явуулж, судалгааны үр дүнг нь хөтөлбөрийн шинэчлэлтэд ашигладаг.
- Төгсөгчдийн ажил эрхлэлт сүүлийн 5 жилийн дунджаар 86.4 хувьтай байгаа нь хөдөлмөрийн зах зээлд шаардлага хангахуйц мэргэжилтэнг бэлтгэж буй нь харагдаж байна.

### **Зөвлөмж:**

- Бакалаврын төгсөлтийн дараах мэргэжил дээшлүүлэх дунд шатны мэргэшүүлэх богино хугацаат сургалтуудыг зохион байгуулахад анхаарах

## **7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх**

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

### **Илрэл нотолгоо:**

- АНУ-ын Дээд боловсролын чанарын баталгаажуулалтын байгууллага болох ACBSP-ээр 2012 оны 5 сард “Маркетинг” хөтөлбөр магадлан итгэмжлэгдсэн.
- Маркетингийн хөтөлбөрийн төгсөгчид мэргэжлийн салбартаа хүлээн зөвшөөрөгдөж буй байдал нь төгсөгчдийн карьер өсөлтийн судалгаанаас тодорхой харагдаж байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрөөр төгсөгчид нь мэргэжлийн салбартаа хүлээн зөвшөөрөгдөхүйц бөгөөд удирдах түвшний албан тушаалуудад ажиллаж байна.
- Төгсөгчдийн мэдлэг, ур чадварын үнэлгээнүүд нь 70 хувиас дээш байгаа нь хөтөлбөрийн үр дүн сайн байгааг илэрхийлж байна.

##### **Анхаарах асуудал:**

- Төгсөгчдийн дотоодын болон гадаадын дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцах байдалд онцгой анхаарах
- Төгсөгчдийг дотоод, гадаадын тэтгэлэгт хөтөлбөрт хамруулахад чиглэсэн төрөл бүрийн арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлэхэд анхаарах

#### **7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан	Хэсэгчлэн хангасан	Хангааг үй	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	3			
2	Сургалтын үйл ажиллагаа	3			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2	3.1		
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	5			
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	5			
6	Багшийн үйл ажиллагаа	3	6.1		
7	Чанарын үнэлгээ баталгаажуулалт	3			
<b>Дүгнэлт</b>		Бүрэн хангасан			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн “Маркетинг” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул шалгуурыг “БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Бизнес, удирдлагын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагч, доктор, дэд проф ..... О.Бурмаа

Шинжээчийн багийн гишүүн, доктор, зөвлөх проф ..... Л.Отгонцэцэг

Шинжээчийн багийн гишүүн, доктор, дэд проф ..... С.Бурмаа



## НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

<b>Сургуулийн нэр</b>	СЭЗИС
<b>Хөтөлбөрийн нэр</b>	Маркетинг
<b>Хөтөлбөрийн индекс</b>	D041401
<b>ЗӨВЛӨМЖ</b>	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> <li>- Мэргэжлийн хөтөлбөрийн харьцуулалтыг хийхдээ дотоодын төрийн болон хувийн өмчийн их, дээд сургуулийн хөтөлбөрийн тоог нэмэгдүүлэх, онцлог талуудыг тодорхойлох</li> <li>- СЭЗИС-ийн “Маркетинг” хөтөлбөрийн бусад ижил төрлийн хөтөлбөрөөс ялгагдах онцлогийг хөтөлбөрийн зорилго дээр илүү тодорхой харьцуулж харуулах</li> <li>- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг (PLO) сайжруулан шинэчлэхдээ хөтөлбөрөөр суралцагчдын зөөлөн ур чадварыг нэмэгдүүлэхэд анхаарах</li> </ul>
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>- Энтерпренер их сургууль болох зорилго болон хөтөлбөрийн багийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чиглэлтэй уялдуулан сургалтын хөтөлбөрийн агуулгыг тогтвортой маркетинг, нейромаркетинг, дижитал маркетинг, маркетингийн судалгаа, шинжилгээ гэсэн чиглэлд хөтөлбөрийн сайжруулалт хийж хөгжүүлэх</li> <li>- Сургалтын арга зүйг хэрэгжүүлж буй байдлын гүйцэтгэлийг үнэлэхдээ түүврээр бус мэргэжлийн хөтөлбөрт хамаарах бүхий л хичээлүүдээр хийх</li> <li>- Сургалтын үр дүнг үнэлэх (оюутан, төгсөгч, ажил олгогчийн сэтгэл ханамж) олон талт үнэлгээний системийг хэрэгжүүлдэг боловч хийгдсэн судалгааны үр дүнгүүдийг нэгдсэн байдлаар өөр хооронд нь уялдуулан сайжруулах</li> </ul>
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	<ul style="list-style-type: none"> <li>- Маркетинг мэргэжлийн хөтөлбөрийн үйл ажиллагаа, сургалтын заах арга зүй, зохион байгуулалтын “онцлог” талуудыг нийтэд нээлттэй болгох, давуу талуудыг сурталчлах замаар олон нийтийн маркетингийн мэдлэгийг сайжруулах</li> <li>- Цахим сургалтын олон талт арга зүй, дэд бүтцээ ашиглан богино хугацааны маркетингийн мэргэшүүлэх сургалтыг бизнес эрхлэгчдэд, гадаадад суугаа Монголчуудад санал болгох</li> <li>- Олон улсын стандартад нийцсэн боловсролын үйлчилгээг үзүүлэхийн тулд Чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, СЭЗИС-ийн “Чанарын бодлого”-ыг боловсруулах</li> </ul>
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> <li>- СЭЗИС-ийн сургалтын үйл ажиллагаанд тохирох мэдээллийн аюулгүй байдлыг хангах, ачаалал даах, хэмнэлттэй технологийг тасралтгүй нэвтрүүлж сайжруулах</li> <li>- Маркетинг хөтөлбөрийн багш нарыг солилцооны тэтгэлгээр докторын сургалтад хамруулах, хамтран удирдах</li> <li>- Тэнхим, хөтөлбөрийг орлогын өөр эх үүсвэртэй болгох, хөшүүрэг, дэмжлэг үзүүлэхэд удирдлагын зүгээс анхаарч, багш нарын санал санаачлагыг дэмжих</li> <li>- Маркетингийн мэргэжлийн хөтөлбөрийг сурталчилан таниулах фейсбүүк хаяг нээх</li> <li>- Олон нийтийн мэдээлэл харилцааг тогтмол хариуцан гүйцэтгэх ажлыг тухайн нэг хүнд даалгаж ажиллуулах</li> </ul>
Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> <li>- Оюутны сайн дурын клубүүдийн үйл ажиллагаа, тэргүүн туршлагыг нийтэд ил тод болгох.</li> <li>- Иргэн хүн насан туршдаа суралцах, тасралтгүй мэргэжил, мэргэшлээ дээшлүүлэх хэрэгцээ шаардлагыг нийгэмд ойлгуулах, идэвхижүүлэх</li> <li>- СЭЗИС-н хамтын ажиллагааг өргөжүүлж, туршлагатай багш-оюутныг төрийн бодлогоор санхүүжүүлж, Монгол хэрэглэгчийн зан төлөвийн суурь судалгааг Нейромаркетингийн лабораторт хийлгэх.</li> </ul>

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>- Гадаадын сургуулиудтай хамтарсан докторын хөтөлбөрт багш нарыг хамруулж, зэрэг хамгаалахад дэмжлэг үзүүлэх</li> <li>- Хичээлийн хамтлагууд хоорондоо туршлагаа хуваалцаж хэлэлцүүлдэг байвал зүгээр</li> <li>- Багш нарын судалгааны ажлын чанарыг сайжруулах /Гадаадын нэр хүндтэй /peer review хийгддэг/ сэтгүүлүүдэд өгүүлэл хэвлүүлдэг болох/</li> <li>- Багш, ажилтнуудыг аттестатчилдаг болох</li> </ul>
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ul style="list-style-type: none"> <li>- Бакалаврын төгсөлтийн дараах мэргэжил дээшлүүлэх дунд шатны мэргэшүүлэх богино хугацаат сургалтуудыг зохион байгуулахад анхаарах</li> <li>- Оролцогч талуудын судалгааг хийж буй нь сайшаалтай боловч зөвхөн тоон үр дүнг гаргах бус, боловсруулалт хийж, уялдааг сайжруулах</li> </ul>
<b>ШААРДЛАГА</b>	
Шалгуур 3.1 Сургалтын орчин	<ul style="list-style-type: none"> <li>- Оюутнуудаас авсан сэтгэл ханамжийн санал асуулгын судалгааны 60% нь суралцах орчны цахилгаан, дулаан, цэвэрлэгээ үйлчилгээтэй холбоотой гомдол байсан. Иймээс сургуулийн ажил үйлчилгээг сайжруулах, чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх</li> </ul>
Шалгуур 6.1 Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого	<ul style="list-style-type: none"> <li>- Мэргэжлийн хөтөлбөрт хамаарах эрдмийн зэрэг, цолтой багш нарын тоог нэмэгдүүлэх</li> </ul>

## IV.Ярилцлагад оролцогчдын нэрс

### I. Багш нарын нэрс

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилласан жил	Заадаг хичээл
1	Тэрбиш АЛТАНГЭРЭЛ	Ахлах багш	MBA	9	МКТ441-Хэрэглэгчийн зан төлөв, МКТ446-Маркетингийн орчин үеийн асуудлууд
2	Ганболд БОЛОР- ЭРДЭНЭ	Багш	MBA	6	МКТ221-Маркетингийн үндэс
3	Батмөнх ГАНШАГАЙ	Ахлах багш	MBA	16	МКТ332-Үйлчилгээний маркетинг, МКТ331-Маркетингийн менежмент
4	Сайнбаяр МӨНХБАЯР	Ахлах багш	MBA	13	МКТ221-Маркетингийн үндэс МКТ433-Маркетингийн харилцаа МКТ331-Маркетингийн менежмент
5	Банзрагч НАНДИН- ЭРДЭНЭ	Ахлах багш	MMKtg, MBA	18	МКТ431-Борлуулалтын менежмент
6	Сандагдорж САЙН-ОД	Ахлах багш	MBA	15	МКТ341- Брэндийн менежмент МКТ432-Маркетингийн судалгаа, шинжилгээ МКТ7111- Стратегийн маркетингийн менежмент
7	Жаргалсайхан СУВД-ЭРДЭНЭ	Ахлах багш	MBA	8	МКТ435- Олон улсын маркетинг МКТ221-Маркетингийн үндэс
8	Тамир ТӨГӨЛДӨР	Багш	MBA	7	МКТ442- Жижиглэн худалдааны менежмент МКТ331-Маркетингийн менежмент МКТ221-Маркетингийн үндэс

## II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал
1	Н.Өнөболд	1	Улаанбаатар хот
2	Ч.Сарнай	1	Улаанбаатар хот
3	Б.Хаш-эрдэнэ	1	Орхон аймаг
4	Ч.Анхзаяа	1	Хөвсгөл аймаг
5	О.Минжээ	1	Улаанбаатар хот
6	Э.Сувд-эрдэнэ	2	Архангай аймаг
7	Б.Хантүшиг	2	Улаанбаатар хот
8	Г.Билгүүн	2	Улаанбаатар хот, "Оюуны хээ" клуб
9	Б.Оюундарь	3	Улаанбаатар хот, "Радокс" клуб
10	Б.Мөнх-эрдэнэ	3	Говьсүмбэр аймаг
11	Ө.Эгшиглэн	3	Улаанбаатар хот
12	Ч.Минжинсор	4	Сүхбаатар аймаг
13	Г.Энх-амар	4	Дархан-уул аймаг, "Хэмнэл" клуб
14	Ч.Буюнжаргал	4	Дорноговь аймаг
15	Б.Мандхай	4	Улаанбаатар хот
16	Д.Хулан	4	Улаанбаатар хот, "Агшин" клуб
17	П.Бүүвэйбаатар	4	Улаанбаатар хот, "Радокс" клуб
18	Т.Маралмаа	4	Улаанбаатар хот, "Радокс" клуб
19	А.Анужин	4	Улаанбаатар хот, "Радокс" клуб
20	Б.Баясгалан	4	Улаанбаатар хот, "Радокс" клуб

## III. Ажил олгогчдын нэрс

№	Нэрс	Байгууллага	Албан тушаал
1	Мөнхтуяа	АПУ ХК	Маркетингийн албаны дарга
2	Саруул-Оюут	Мобиком	Хүний нөөц
3	Оюунчимэг	Таван Богд	Захирал
4	Долгорсүрэн	Ток Ток ХХК	Гүйцэтгэх захирал
5	Энхтуяа	MCS-Хүний нөөц	Хүний нөөцийн ахлах ажилтан
6	Амарзаяа	ТЕСО ХХК	Хүний нөөцийн дарга
7	Оюун	QSC ХХК	Хүний нөөц хариуцсан төслийн менежер
8	Хишигсүрэн	Хөгжлийн Шийдэл ТББ	Төсөл хөтөлбөр хариуцсан менежер
9	Янжиндулам	МИРИМ Консалтинг	Ахлах судлаач
10	Лхам	Юнител	Маркетинг-Төлөвлөлтийн ахлах менежер
11	Энхбаясгалан	Viral	Гүйцэтгэх захирал
12	Амарцэцэг	Монголын маркетингийн холбоо	Ерөнхий менежер

IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог	Нэр	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал
1	Мөнхжаргал	Бат-Оргил	2020	Тэсо Рийл Эстэйт ХХК	Маркетингийн ахлах менежер
2	Лхагважав	Энхмандах	2020	Mobicom	Борлуулалтын шинжээч
3	Батбаяр	Баттэнгис	2020	Spice kitchen	Салбар хариуцсан захирал
4	Тамир	Дөлгөөн	2020	Mobicom	Мэргэжилтэн
5	Батдорж	Галмандах	2019	Netcapital BBSB	Бүтээгдэхүүн хөгжлийн менежер
6	Энхбаяр	Амартүвшин	2019	Худалдаа хөгжлийн банк	Маркетингийн менежер
7	Ганбат	Алдармаа	2019	Oveda ХХК	Маркетингийн менежер
8	Мөнхжаргал	Хулан	2019	Хан төгөл хотхон	Маркетингийн менежер
9	Наранцогт	Адьяа	2019	ММCG ХХК	Судалгааны менежер
10	Ишжамц	Баттулга	2019	Mobinet LLC	Мэргэжилтэн
11	Түвшинбат	Удвал	2019	Mobicom	Маркетингийн мэргэжилтэн
12	Дэлгэрбат	Мөнхбаясгалан	2018	Гоёл кашмер	Маркетингийн менежер
13	Сайханзориг	Оюундалай	2018	Хаан банк	Хүний нөөцийн удирдлагын газрын мэргэжилтэн
14	Чэнь	На	2018	G&alpha development ХХК	Захирал
15	Дрриламаятав	Бат-Эрдэнэ	2018	Сувади-Арт ХХК	Гүйцэтгэх захирал
16	Мягмарсүрэн	Энхжин	2018	Оюуны ундраа групп	Маркетингийн мэргэжилтэн
17	Баяраа	Баяртуяа	2017	Тэсо корпораци	Экспортын брэнд менежер
18	Наранбаатар	Болдбаатар	2017	Сүүдэр Ай Эн Си ХХК	Үйл ажиллагаа хариуцсан захирал
19	Жаргалсайхан	Хүнболд	2017	СЭЗИС	багш
20	Баярхүү	Хоролсүрэн	2016	Novelsoft LLC	Маркетингийн мэргэжилтэн
21	Хүрэлсүх	Аюуш	2016	Голомт банк	Дижитал маркетингийн менежер
22	Ганчимэг	Гэрэлчимэг	2016	Skytel ХХК	Дижитал бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн мэргэжилтэн
23	Болд	Хатанмөрөн	2016	DupliTrade Mongolia	Гүйцэтгэх захирал

**V.Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**  
/албан бичгийг оруулах/



**САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН  
ИХ СУРГУУЛЬ**

13381 ш/х-49, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
Энхтайваны өргөн чөлөө 5, Утас/Факс: (976-11) 45 83 78,  
И-мэйл: info@ufe.edu.mn, Вэбсайт: www.ufe.edu.mn

2022.01.21 № 5/34

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН  
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ  
ЗӨВЛӨЛДИЙН АЖЛЫН АЛБАНД**

**Шинжээчдийн үнэлгээний тайланд  
хариу хүргүүлэх тухай**

СЭЗИС-ийн Маркетинг хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийсэн шинжээчдийн багийн үнэлгээний тайланг 2022 оны 01-р сарын 17-ны өдөр хүлээн авлаа. БМИҮЗ-өөс томилогдсон доктор О.Бурмаа ахлагчтай, доктор Л.Отгонцэцэг, доктор С.Бурмаа нарын бүрэлдэхүүнтэй шинжээчдийн баг 2022 оны 01-р сарын 5, 6-ны өдрүүдэд тус сургуульд хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж, өөрийн үнэлгээний тайлан боловсруулсан багийн гишүүдтэй хамтран ажиллаж, өөрийн үнэлгээний тайлан болон түүний нотлох баримтуудыг судалж, сургуулийн номын сан, анги танхим, сургалтын орчинтой танилцаж, удирдлага, багш, оюутан, төгсөгч, ажил олгогч нарын төлөөлөлтэй цахим болон биечилсэн уулзалтуудыг зохион байгуулж богино хугацаанд өндөр бүтээмжтэй ажилласанд талархаж байна.

Шинжээчдийн бичсэн үнэлгээний тайланд СЭЗИС-ийн Маркетинг хөтөлбөрийн туршлага, онцлог зүйлсийг шалгуур тус бүрээр тодорхойлж өгсөн нь бидний хийж буй ажлын үнэ цэнэ, ахиц дэвшил, өөрчлөлт хөгжлийг тун гярхай олж харж дүгнэсэн байна. Мөн энэхүү тайланд сургууль болон хөтөлбөрийн зүгээс анхаарвал зохих асуудлыг дурдаж, тэдгээрийг сайжруулах зөвлөмжүүдийг оруулж өгсөн ба тэдгээрийг ажлын төлөвлөгөөнд тусган, хэрэгжүүлснээр сургууль болон хөтөлбөрийн үйл ажиллагааг тасралтгүй сайжруулахад үнэтэй хувь нэмэр оруулна гэж үзэж байна.

2021 оны 04-р сард батлагдсан сургуулийн 2021-2031 оны стратегийн төлөвлөгөөний дагуу СЭЗИС-ийн бүх алба нэгжүүд дунд хугацааны (3 жил), богино хугацааны (1 жил)-ийн төлөвлөгөөнүүдийг боловсруулан, хэрэгжүүлж байгаа ба эдгээр санал зөвлөмжтэй холбоотой сайжруулах асуудлууд бүхэлдээ хэрэгжиж эхлэх үндсэн суурь нь тавигдсан. Сургалт, судалгааны үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журмын шинэчлэл тасралтгүй хийгдэж байна. Үнэлгээний тайланд сургуулийн орчин болон багшийн зэрэглэлтэй холбоотой шаардлага тавигдсан бөгөөд тэдгээрт түлхүү анхаарч ажиллах нь чухал байгааг бид мөн онцолж байна. 2024 он хүртэлх дунд хугацаанд сургалт судалгааны орчин нөхцөлийг дээд боловсролын олон улсын жишигт үе шаттайгаар нийцүүлэх зорилтыг эрчимжүүлж ажиллана. Энэ хүрээнд СЭЗИС-ийн Оюутны холбоотой хамтран орчин сайжруулалтын асуудлыг хэлэлцэж, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх арга хэмжээнүүдийг авч ажиллах чиглэл баримтална.

Маркетинг мэргэжлийн хөтөлбөрт хамаарах эрдмийн зэрэг, цолтой багш нарын тоог нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага байгаа бөгөөд сургуулийн зүгээс энэхүү шалгуурыг хангах, доктор зэрэгтэй багшийн эзлэх хувийг 2024 онд 40 хувьд хүргэхээр онцгойлон анхаарч ажиллаж байна.

Маркетингийн бакалаврын хөтөлбөрийн өөрийн үнэлгээнд тайланд үнэлгээ хийж, нухацтай дүгнэлт өгөх туршлагатай баг, мэргэжилтнүүдийг шуурхай томилж ажиллуулсан БМИҮЗ-ийн ажлын албаны хамт олонд талархлаа илэрхийлье.

БАКАЛАВРЫН СУРГАЛТ, СУДАЛГАА ХАРИУЦСАН  
ПРОРЕКТОР Б.МӨНХЗАЯА



## ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо) 2022-01-25

[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа
Магадлан итгэмжилнэ	5 жил

**Зөвлөмж/Recommendations/**

## ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)  
.....[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

**Зөвлөмж/Recommendations/**